



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/261

Булган сум


Хоол үйлдвэрлэлийн ажиллагсдын спортын наадамд Булган аймгийн төлөөллийг оролцоход дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 181.1.6, 18.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.9, "Хүнсний тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 14 дүгээр зүйлийн 14.1.3, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5.1, 10.6.1, Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын 2/г дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орхон аймагт 2024 оны 04 дүгээр сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгуулагдах Монгол үндэсний хоол, идээ ундааны "Улсын аварга тогооч" шалгаруулах анхдугаар уралдаан болон хоол үйлдвэрлэлийн ажиллагсдын спортын наадамд Булган аймгийн төлөөллийг оролцоход дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах 3,707,750 (гурван сая долоон зуун долоон мянга долоон зуун тавь) төгрөгийг Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлын 16-д тусгагдсан Үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны
10 дүгээр сарын 19-ний өдрийн А/26 дугаар
захирамжийн хавсралт

"Улсын аварга тогооч" шалгаруулах ур чадварын уралдаан, спортын анхдугаар
наадамд оролцоход шаардлагатай төсөв

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт үнэ /төг/
1	2	3	4	5	6
1	Булганаас Орхон аймаг ирэх, очих 60*2 = 120 км /5 машин = 600 км/ Дотор = 100км	100 км-д 15 литр	90	2550	229500
			15	2550	38250
2	Орон нутгийн бренд хоолны төрөлд /гэрийн даалгавартай/	хүн	3	80000	240000
3	Малын дотор мах, дайвар бүтээгдэхүүнээр хийх хоолны төрөл	хүн	2	80000	160000
4	Сүү, цагаан идээгээр хийх хоолны төрөлд	хүн	1	80000	80000
5	Багын хар хайрцагны төрөл /багийн хүн тус бүр /	хүн	3	150000	450000
6	Орчин үеийн Монгол хоолны төрөл	хүн	1	80000	80000
7	5 төрөлт Спортын арга хэмжээний хураамж /50000 төг – 200000 төг/	төрөл	5	126000	630000
8	Засаг даргын нэрэмжит шагнал, Орон нутгийн брэндийн гарын бэлэг	хүн	20	40000	800000
9	Оролцогчдын 2 өдрийн байрны зардал	хүн	20	50000	1000000
	Нийт				3,707,750